



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2026 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
даргыг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.19 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Шарав овогтой Бат-Эрдэнийг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН



П.БАЯР

Ш.БАТ-ЭРДЭНЭ

Б.БОЛОРМАА

Х.БУЛГАНТАМИР

Г.ГИЙХНАРАН

Ж.ЗОЛЗАЯА

Т.ГАНБААТАР

Н.ОТГОНЧИМЭГ

Л.ЭНХБАЯР

1526010067



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2026 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 28

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн
хороодыг шинэчлэн байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2, 81.4 дэх хэсгүүд, "Компанийн засаглалын кодекс"-ийн 2.3, 2.4, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.34, 5.35, 5.37 дахь хэсгүүд, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 12 дугаар зүйлийн 12.1, 12.5 дахь хэсгүүд, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Ж.Золзаяа	Хорооны дарга
Н.Отгончимэг	Хорооны гишүүн
Б.Болормаа	Хорооны гишүүн

2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Эрсдэл /комплаенс/-ийн удирдлагын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Х.Булгантамир	Хорооны дарга
П.Баяр	Хорооны гишүүн
Л.Энхбаяр	Хорооны гишүүн

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

П.Баяр	Хорооны дарга
Ж.Золзаяа	Хорооны гишүүн
Г.Гийхнаран	Хорооны гишүүн

1526010065

4. Төлөөлөн удирдах зөвлөлийн Цалин урамшууллын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Н.Отгончимэг
Т.Ганбаатар
Х.Булгантамир

Хорооны дарга
Хорооны гишүүн
Хорооны гишүүн

5. Хороодын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг хороодын дарга нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.БАТ-ЭРДЭНЭ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 31

Улаанбаатар хот

Гишүүнчлэлээс хасах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5.7.20 дахь заалт, “Гишүүнчлэлийн журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1.3.3. дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 166 дугаар тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Өндөрхаан инвест ҮЦК “ХХК-ийг Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнчлэлээс хассугай.

2. Гишүүнчлэлээс хассантай холбогдуулан мэдээллийн санд зохих өөрчлөлт оруулах, олон нийтэд мэдээлэх, холбогдох мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д тус тус хүргүүлэх ажлыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Ж.Золзаяа)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.БАТ-ЭРДЭНЭ

1526010069



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Гишүүнчлэлээс хасах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Монголын хөрөнгийн бирж” хувьцаат компанийн Дүрмийн 5.7.20 дахь заалт, “Гишүүнчлэлийн журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1.3.3 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны 04 дугаар сарын 09-ний өдрийн 123 дугаар тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Масдак ҮЦК “ХХК-ийг Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн гишүүнчлэлээс хассугай.

2. Гишүүнчлэлээс хассантай холбогдуулан мэдээллийн санд зохих өөрчлөлт оруулах, олон нийтэд мэдээлэх, холбогдох мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д тус тус хүргүүлэх ажлыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороонд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.БАТ-ЭРДЭНЭ

1526010072



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 29

Улаанбаатар хот

Маргаан таслах зөвлөлийн гишүүнийг нөхөн томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.27, 8 дугаар зүйлийн 8.1 дахь хэсэг, "Биржийн дэргэдэх маргаан таслах зөвлөлийн ажиллах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2, 2.4.6, 2.6, 2.10 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн ахлах шинжээч Н.Цогтбаяр нь албан тушаалаасаа чөлөөлөгдсөн тул Маргаан таслах зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Гэрээ, эрх зүй, гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн А.Бүдээг Биржийн дэргэдэх маргаан таслах зөвлөлийн гишүүнээр 2027 оны 02 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл хугацаагаар нөхөн томилсугай.

3. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон Биржийн дэргэдэх маргаан таслах зөвлөлийн ажиллах журмыг үйл ажиллагаандаа тогтмол мөрдөж, хараат бус, шударгаар ажиллахыг А.Бүдээд үүрэг болгосугай.

4. Маргаан таслах зөвлөлийн гишүүний сарын цалинг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байдлаар тооцож, хурлын ирцийг үндэслэн олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Нарангэрэл)-д зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Ц.Шатар)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ш.БАТ-ЭРДЭНЭ

1526010074